



МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 09 сарын 26 өдөр

Дугаар 18

Улаанбаатар хот

Г Хуульчдын холбооны Хяналтын Г Зөвлөлийн гишүүнийг томилох, батламжлах тухай

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.7 дахь, 51 дүгээр зүйлийн 51.2 дахь хэсэг, Монголын Хуульчдын холбооны дүрмийн 4.13 дугаар зүйлийн 1.7 дахь хэсэг, 7.2 дугаар зүйлийн 2 дахь, 4 дэх хэсэг, Өмгөөлөгчдийн хорооны Удирдах зөвлөлийн 2026 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн 05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Хуульчдын холбооны зөвлөлийн ээлжит хурлаас ТОГТООХ нь:

1. Хуульчдын холбооны Хяналтын зөвлөлийн гишүүнээр өмгөөлөгчдийн төлөөлөл болох Даржаагийн Баттулгыг томилсугай.
2. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Зөвлөлийн 2023 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 18 дугаар тогтоолоор томилогдсон Жадамбаагийн Эрдэнэбилэгийг Хяналтын зөвлөлийн гишүүнээс чөлөөлсүгэй.
3. Энэ тогтоолыг 2026 оны 09 дүгээр сарын 26-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ХУРАЛ ДАРГАЛАГЧ



М.МӨНХБАТ